



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,

Энхтайваны өргөн чөлөө 23, Юу Би Эйч төв, 8 давхар,

Утас: 26 01 82

2022.06.27 № 01/1393

танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
С.ТӨГСДЭЛГЭР ТАНАА**

Эрүүл мэндийн салбарын хяналтад байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн өөрийн байгууллагад холбогдох арга хэмжээний биелэлтэд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хүргүүлж байна.

Хавсралт: 23 хуудастай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 160919



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

/2022 оны эхний хагас жилийн байдлаар/

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, шийдвэр, хуралдааны тэмдэглэлийн Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан тогтоол, шийдвэр, зүйл, заалтуудын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээ мэдээллийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар гаргуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Эрх зүйн актын биелэлтийн хувийг тогтоохдоо Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 374 дүгээр тогтоолыг тус тус удирдлага болгон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН

Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн нийт 113 тогтоол, шийдвэрийн 225 заалтаас Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үндсэн чиг үүрэгт хамаарах Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Улсын Их Хурал, Улсын их хурлын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, тэмдэглэл, албан даалгавар, Ерөнхий сайдын захирамж 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 19 тогтоол, шийдвэрийн 36 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан байна.

Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг тайлангийн хяналтад авсан 36 заалтын 26 заалт бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн үнэлгээтэй, 7 заалт хэрэгжих шатанд буюу 70 хувийн үнэлгээтэй, 2 заалт хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн үнэлгээтэй, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй заалт 1 гэж дүгнэгдсэн ба биелэлтийн дүн **дунджаар 90,0 хувьтай** үнэлэгдэв.

Нийт 19 тогтоол, шийдвэрийн хяналтад авсан 36 заалтын хэдэн заалт нь аль шийдвэрт хамаарч байгааг нарийвчлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Монгол Улсын 4 хуулийн 7 заалт хяналтад авсны 7 заалт бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай үнэлэгдэж, биелэлтийн дундаж 100 хувьтай;

- Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 заалт хяналтад авсны 1 заалт бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай үнэлэгдэж, биелэлтийн дундаж 100 хувьтай;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 зөвлөмжийн 4 заалт хяналтад авсны 1 заалт бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай, 2 заалт хэрэгжих шатанд 70 хувьтай 1 заалт хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж 67,5 хувьтай;
- Засгийн газрын 5 тогтоолын 12 заалт хяналтад авсны 10 заалт бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай, 1 заалт хэрэгжих шатанд 70 хувьтай, 1 заалт хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж 91,6 хувьтай;
- Засгийн газрын хуралдааны 5 тэмдэглэлийн 7 заалт хяналтад авсны 3 заалт бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай, 3 заалт хэрэгжих шатанд 70 хувьтай, 1 заалт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж тус тус үнэлэгдэж биелэлтийн дундаж 85 хувьтай;
- Засгийн газрын 2 албан даалгаврын 5 заалт хяналтад авсны 4 заалт бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай, 1 заалт хэрэгжих шатанд 70 хувьтай тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж 94 хувьтай байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээний дундаж дүн 90,0 хувьтай байна. Тодруулбал шинээр гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа харьцангуй шуурхай зохион байгуулагдаж байгаа нь хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн явц, үр дүнгээс харагдаж байна.

ТАВ. НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт дундажаар 90,0 хувьтай буюу салбарын хэмжээнд тогтмол хэрэгжилттэй байгаа хэдий ч газар хэлтэст дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, тайланг Захиргаа, удирдлагын газарт 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлж ажиллахыг бүх газар, хэлтэст үүрэг болгох саналыг газрын даргад хүргүүлж байна. Үүнд:

* Тогтоол шийдвэрийн биелэлтэд явцын буюу хагас жилийн байдлаар хэрэгжих шатанд байгаа заалт бүрийн хэрэгжилтийг сайжруулах, хэрэгжилт хангалтгүй дүгнэгдсэн заалтуудын биелэлтийг хангаж ажиллах;

* Тогтоол шийдвэрийн биелэлтийг гаргахдаа хариуцлагатай хандаж, өөрсдийн салбар болон газрын биелэлтийн дундаж үнэлгээг харьцуулан аль түвшинд хэрэгжиж байгаа, мөн өмнөх тайлагналтаас гарсан өөрчлөлтийн дүнд шинжилгээ хийж ажиллах,

* Газар, хэлтсийн дарга нар тайланг нягтлан хянаж, баталгаажуулж зөвшөөрсний үндсэн дээр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэх;

* Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, түүний тайлагналтыг сайжруулах. Тухайлбал нэг ажлыг хэд хэдэн заалтын биелэлтэд тайлагнах, тухайн заалтад хамааралгүй биелэлт гаргах, хэт нурших, үр дүнг бичихгүй байх, найруулгын болон үг, үсгийн алдаа гаргах зэрэг нийтлэг алдаа дутагдлыг дараа

дараагийн тайланд засаж сайжруулан, үйл ажиллагаандаа анхаарч, тайланг график, хүснэгт ашиглаж, үр дүнг товч, тодорхой, бодитой хариуцлагатай тайлагнахыг газар, хэлтсүүдэд анхааруулах;

* Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлд анхаарч, үйл ажиллагааг эрчимжүүлэх;

* Тогтоол, шийдвэрийн /хуулийн/ асуудал хариуцсан албан тушаалтан нь хяналтад авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр дагавар, ажлын ахиц, өөрчлөлтийн талаарх чанарын ба тоон мэдээллийг хөтөлж ажиллах;

* Нэг удаагийн шинж чанартай, хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, үйл ажиллагаа нь өөр төрийн захиргааны төв байгууллагад шилжсэн, цаашид хэрэгжих боломжгүй болсон тогтоол шийдвэрүүдийг тухай бүрт нь хяналтаас хасуулах тал дээр анхаарч, ажиллаж хэвшихийг тус тус зөвлөмж болгож байна.

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
/2022 оны эхний хагас жилийн байдлаар/

2022 оны 06 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтэн явц	Өөрийн үнэлгээ	Үнэлгээний тайлбар
Монгол Улсын хууль						
1	1	Статистикийн тухай /Шинэчилсэн найруулга/ 1997-06-05 Дугаар 1997.06.05	11.6. Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ. Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна.	Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Захиргаа, удирдлагын газарт эм зүйн сургалт судалгаа, шинжилгээ, статистик, бүртгэл хариуцсан мэргэжилтэн орон тоог газрын даргын 2021 оны А/01 дүгээр тушаалаар батласан салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэдэг нэгж бөгөөд 2022 оны "Эм зүйн үзүүлэлт" гаргасан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
2	2	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Газрын даргын 2021 оны Б/66 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
3	3	Донорын тухай хууль /шинэчилсэн найруулга/	20.3. Донорын цус, цусан бүтээгдэхүүн, сорьц, эд, эрхтнийг улсын хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн хяналтан дор Улсын хилээр нэвтрүүлэх бараанд импорт, экспортын лиценз олгох журам"-ын хүрээнд 2022 оны эхний хагас жилийн байдлаар 6 байгууллагад /Ливер центр, Мон-Адонис, Өөжинмед, Реженератив, ХӨСҮТ, ЭМЯ-Монгол улсад оношлогдох боломжгүй иргэд/ 16 удаагийн экспортын лицензээр 7196 ширхэг цус, цусан бүтээгдэхүүн, сорьц, эд эрхтэнд лиценз олгож ажилласан байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	

4	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29	7.1.14. цар тахлаас хамааралгүйгээр хийгдэж байгаа бүтээгдэхүүний экспортыг хориглохгүй бөгөөд эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, урвалж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, иргэдийн хамгаалах хэрэгсэл, хүнсний болон бусад шаардлагатай барааг улсын хилээр гаргахыг хориглох асуудлыг шийдвэрлэх; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/	2022 оны эхний хагас жилийн байдлаар 2 байгууллагын /Мон-Интра, Ариун Монгол/ 12 экспортын лицензээр 149 нэрийн уламжлалт эм экспортлосон байна. Коронавируст халдварын тухай хуулийн 7.1.14-т заасны дагуу эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, урвалж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, иргэдийн хамгаалах хэрэгслийг улсын хилээр гаргаагүй.	Бүрэн хэрэгжсэн 100%	
		7.1.15. цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай хүнсний болон бусад нөөцтэй байх ба нөөцийн жагсаалтыг баталж, түүнийг бүрдүүлэхтэй холбоотой 3 сараас доошгүй хугацааны зардлыг шийдвэрлэх; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/	Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны А/163, А/603 тушаалын дагуу цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн судалгааг тогтмол хийж, хэрэгцээг халдварын тархалтын тооцоололтой уялдуулан тооцоолж, нөөц бүрдүүлэх чиглэлээр ханган нийлүүлэх байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээллийг улсын хэмжээний нөөцийн нэгдсэн программ butgel.mohs.mn -аар өдөр бүр, зах зээлийн нөөц болон импортын мэдээллийг ханган нийлүүлэх байгууллагуудаас 7 хоног бүр авч, мэдээний санд бүртгэж байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг удирдамжид нийцүүлэн гаргаж, 6 нэрийн вирусийн эсрэг эм, 9 нэрийн антибиотик, 5 нэрийн амилуулах тусламж, үйлчилгээний эм, 11 нэрийн дуслын шингэн, шинж тэмдгийн эсрэг эм, 14 нэрийн хувийн хамгаалах хэрэгслийн хэрэгцээ ба шаардлагатай төсвийг тухай бүр ДЭМБ, ХӨСҮТ-өөс ирүүлсэн КОВИД-19 халдварын тохиолдлын таамаглалд үндэслэн тооцоолсон.	Бүрэн хэрэгжсэн 100%	

6		7.1.23. цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах; /Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/	2022 оны эхний хагас жилд цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах зорилгоор ЭЗХХЗГ, ЭМЯ, ГХЯ, ЗТХЯ болон МИАТ ТӨХК-тай хамтран тусгай үүргийн нислэгээр БНХАУ, БНСУ-аас 65,7 тонн, төмөр замаар 383 чингэлэг буюу 15,320 тонн эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, тоног төхөөрөмж бүхий ачааны мэдээллийг БНХАУ-ын талд хүргүүлэн татан авах ажлын зохион байгуулсан. Украин улсад үүссэн цэргийн ажиллагаанаас шалтгаалж эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдлаас сэргийлэх зорилгоор саатсан гадаад валют гүйлгээний хүсэлтийг ханган нийлүүлэх байгууллагуудаас 7 хоног бүр авч, Монгол банкнд хүргүүлэн 68 байгууллагын 79 тэрбум төгрөгийн гүйлгээг гаргасан. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын эмийн төсөвт хэмнэлт үүсгэх, эмнэлгийн тусламж үйлчилгээнд коронавируст халдвар (КОВИД-19-ын)-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг жигд, хүртээмжтэй хангах зорилгоор 10 нэрийн эм болон 11 нэрийн түргэвчилсэн оношлуур нуклейн хүчил ялгах болон ПГУ оношлуурыг шинээр ерөнхий гэрээнд оруулсан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим дэлгүүрээс нийт 39 тэрбум төгрөгийн эм, оношлуур болон дагалдах хэрэгслийн захиалга хийгдэж, улсын төсвөөс 19 тэрбум төгрөгийн хэмнэлт хийсэн байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
7		9.5. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цар тахлын халдварын эмчилгээнд шаардлагатай шинэ төрлийн эм, ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг түргэвчилсэн журмаар бүртгэнэ.	2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Хүний эмийн зөвлөлийн хурлаар Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хэрэглэх 3 нэрийн вирусийн эмийг хэлэлцүүлж, МУ-ын эмийн бүртгэлд бүртгэсэн. Үүнд: 1. Фавивир /Фавипиравир/ 2. Ковифор /Ремдесивир/ 3. Нинавир /Ремдесивир/ Мөн ХЭЗ-ийн БОСЗ-ийн 4 удаагийн хурлаар Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх 7	Бүрэн хэрэгжсэн 100%	

				нэрийн түргэвчилсэн оношлуурыг улсын бүртгэлд бүртгэсэн. Үүнд: 1. SARS-CoV-2 Antigen Test Kit 2. NOVA Test® SARS-CoV-2 Antigen Rapid Test Kit 3. PCL Covid-19 Ag Gold 4. SARS-CoV-2 Ag Diagnostic Test Kit (Colloidal Gold) 5. CoviFlu Ag Duo 6. EZERTM Flu & Covid-19 Antigen Duo Rapid Test 7. Sars-CoV-2 Antigen Test Kit"	
Ерөнхийлөгчийн зарлиг					
				Эм, биобэлдмэлийн хяналтын чиг үүрэг нь 2022 оныг хүртэлх хугацаанд мэргэжлийн хяналтын байгууллагад харьяалагдаж байсан бөгөөд МУ-ын Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор нийслэл, орон нутгийн улсын байцаагчид ЭЗХХЗГ-т шилжин ирж, 29 улсын байцаагч нийтдээ 1759 эм хангамжийн байгууллага, 2071 эрүүл мэндийн байгууллагад хяналт тавин ажиллаж байна. Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" 2021 оны 106 дугаар тогтоол, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Мэргэжлийн Хяналтын ерөнхий газар хооронд хамтран ажиллах гэрээ, зөвлөн туслах үйлчилгээний хөтөлбөрийн дагуу 21 эмнэлэг, 52 эм ханган нийлүүлэх байгууллага, 106 эмийн сан нийт 179 байгууллагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, 1335 заалттай улсын байцаагчийн 93 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Мөн Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн 25 өргөдөл, 60 албан бичгийг хүлээн авч, хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, хариуг хүргүүлсэн байна.	Бүрэн хэрэгжсэн 100%
ҮАБЗ-ийн зөвлөмж					

6	9	Эм вакцин, биобэлдмэлийн хангамж, нөөц чанар тэдгээрийн аюулгүй байдалд тавих хяналт 2013-01-08 Дугаар 2013_03/03	1. Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа хийх, чанарын баталгаажуулалт, үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл, эм зүйн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт, эмийн гаж нөлөөнд тавих хяналт, зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналтыг зохицуулалтын чиг үүргийг Засгийн газрын хэрэгжүүлэгч Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг Засгийн газрын 2020 оны 222, 2021 оны 378 дугаар тогтоолоор байгуулж, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/23 дугаар тушаалаар байгууллагын стратеги, зохион байгуулалтын бүтцийг баталснаар 6 газар, 2 хэлтэс, 1 лабораторитой, 132 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн.	Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа хийх, чанарын баталгаажуулалт, үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл, эм зүйн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт, эмийн гаж нөлөөнд тавих хяналт, зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналтыг зохицуулалтын чиг үүргийг Засгийн газрын хэрэгжүүлэгч Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг Засгийн газрын 2020 оны 222, 2021 оны 378 дугаар тогтоолоор байгуулж, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/23 дугаар тушаалаар байгууллагын стратеги, зохион байгуулалтын бүтцийг баталснаар 6 газар, 2 хэлтэс, 1 лабораторитой, 132 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%
	10		2. Эмийн түгээлтийн шат бүрд эмийн үнийг хянах механизмыг бий болгох;	ЭМДЕГ, Интерактив ХХК болон ЭЭХХЗГ-ын хамтарсан уулзалт зохион байгуулж, Гаалийн мэдүүлгийн систем, Цахим төлбөрийн баримтын систем /И-Баримт/, E-Health, E-Hospital системээс авах цахим мэдээллийн зураглалыг гаргасан. Гаалийн мэдүүлгийн систем, Цахим төлбөрийн баримтын систем /И-Баримт/-тэй холбосноор эмийн түгээлтийн шат бүрд үнийн ил тод байдлыг хангах, хянах нөхцөл бүрдэнэ.	Хэрэгжих шатанд 70%
	11		6. Биологийн идэвхт бүтээгдэхүүнийг сүлжээгээр борлуулж байгааг зогсоох, эрх зүйн орчин бүрдүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудыг сурталчилгаа болон борлуулалтанд оролцохыг хориглох	Хэрэгжиж буй эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд биологийн идэвхт бүтээгдэхүүнийг сүлжээгээр борлуулж байгааг зогсоох, эрүүл мэндийн ажилтнуудыг сурталчилгаа болон борлуулалтанд оролцохыг хориглох тухай эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа тул Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд уг санал өгч ажиллаж байна.	Хэрэгжилт хангалтгүй 30%

7	12	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05	1.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн жагсаалтыг тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээ, гааль, мэргэжлийн хяналтын болон холбогдох бусад байгууллагын саналыг авч НҮБ болон ДЭМБ-аас гаргсан жагсаалтыг үндэслэн тухай бүр шинэчлэн батлах санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын үндэсний аюулгүй байдлын хороо 2022 оны 02 дугаар сард хуралдаж, хийж гүйцэтгэх рага хэмжээний төлөвлөгөө батласан. Уг төлөвлөгөөний дагуу ажлыг хэрэгжүүлж ажиллаж байна.	Хэрэгжих шатанд 70%	
3Г-ын тогтоол						
8	13		1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;	Холбогдох байгууллагын санал, зөвлөмжийг үндэслэн ажлын байрны шинжилгээ хийснээр илэрсэн зөрчлийг арилгуулж, уялдаа холбоог сайжруулахаар газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 1008 дугаар албан бичгээр нийт 10 албан тушаалын тодорхойлолтуудад оруулах саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлээ.	Хэрэгжих шатанд 70%	
	14	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;	Газрын хэмжээнд төрийн жинхэнэ албан тушаалд 15 хүний сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалтыг 2022.01.05-ны өдөр зохион байгуулж төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж, тус сул орон тоог нөхөн томилсон. Мөн төрийн захиргааны удирдах болон бусад албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдыг тусгай шалгалтанд хамруулах санал, захиалгыг ЭМЯ-ны дэргэдэх төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн ба 6 албан тушаалын сонгон шалгаруулалтыг зарлуулж, 34 албан тушаалын захиалгыг хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%	
	15		1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар	Жирэмсний болон амаржсны амралт, хүүхэд асрах чөлөөтэй байгаа 14 төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоонд албан хаагчдыг томилоогүй ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	

			ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх;			
16			1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;	Албан хаагчаас албан томилолтын явцад болон ажлын байранд ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундаа, мансуурах сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, хүйтэн болон халуун зэвсэг, тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис нэвтрүүлэх, хадгалах, ашиглах, хэрэглэхгүй байх асуудлыг газрын даргын 2021 оны 283 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Байгууллагын дотоод журам"-ын 5 дугаар зүйлийн 5.4.2, 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалтуудаар зохицуулсан. 2022 оны хагас жилийн байдлаар албан хаагчид энэ төрлийн зөрчил гаргаагүй.	Бүрэн хэрэгжсэн 100%	
17			1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;	Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, хүнд сурталтай холбоотойгоор үйлчлүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн гомдлыг хянан үзэж, байгууллагын ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шалтгаан нөхцлийг тогтоон ажиглаж, дүгнэлтийг Даргын зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллалаа. Мөн гэмт хэрэг үйлдсэн 1 албан хаагчийг үүрэгт ажлаас чөлөөлсөн.	Бүрэн хэрэгжсэн 100%	
28			1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор, цаг бүртгэлийн төхөөрөмжөөс нийт албан хаагчдын хурууны хээний мэдээллийг устгаж албан даалгаварт заасны дагуу цаг бүртгэлийн төхөөрөмж дээр албан хаагчдыг царайгаар таниулж ажлын цагаа бүртгүүлэх горимд тохиргоо хийсэн. Хуулийн хэрэгжилтийг хангуулах бэлтгэл ажлын тайланг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/866 дугаар албан бичгээр ЭМЯ-ны ТЗУГ-т хүргүүлэн ажиллалаа.	Бүрэн хэрэгжсэн 100%	
19			1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, зөрэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/74 дүгээр тушаалаар шинэчлэн баталж уг журмын 1.8.4-т "Ажилтан хамт ажиллагсад болон удирдах ажилтанд, мөн удирдах ажилтан ажилтандаа аливаа дарамт, шахалт үзүүлэхгүй байх" заалтыг тусгаж	Бүрэн хэрэгжсэн 100%	

				ажилласан. Тайлант хугацаанд удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнаас ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт үзүүлсэн талаарх гомдол, мэдээлэл "Ёс зүйн зөвлөл" болон байгууллагын захиргаанд ирүүлээгүй байна.		
	20	3.. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.		Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан "Дотоод хяналт хийх журам" болон бусад холбогдох эрх зүйн актуудыг тус тус үндэслэн батлагдсан удирдамжийн хүрээнд нийт ажиллагсдын цагийн бүртгэл, цаг ашиглалтад гэнэтийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Хяналт шалгалтын үр дүнг нийт алба хаагчдад танилцуулж, зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.	Бүрэн хэрэгжсэн 100%	
9	21	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139	3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг "Удирдлагын академи" төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг "Удирдлагын академи"-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.	Удирдлагын академаас зохион байгуулсан богино хугацааны цахим сургалтад 5 албан хаагчийг хамруулсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	

10	22	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.	1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.	Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу ТА3-ийн цахим 12 сургалт, байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр цахимаар 9 хурал, зөвлөгөөн зохион байгуулагдсан байна. Төсвийн тухай хуулийн 12.1.4. жилийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийг төсвийн цаглабрыг баримтлан бэлтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх, 8.4.1. төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх гэж заасны дагуу хуулийн хугацаандаа хүргүүлэхээр газар хэлтсийн 2023 оны төсвийн төслийн санлыг авч нэгтгэж байна. 1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулаагүй мөн энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулаагүй болно.	Бүрэн хэрэгжсэн 100%
11	23	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204	9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогддуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Автомашины хэрэглээг хязгаарласан төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжлийг хангах зорилгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.06.13-ны А-1/1236 дугаар албан бичгийн дагуу Засгийн газрын авто баазад 73-21 УБЗ спортеж автомашиныг 2022.06.20-өдөр хүлээлгэн өгсөн. Фургон автомашиныг ЭМЯ-нд хүргүүлж балансаас балансад шилжүүлэх хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар албан бигээр хүргүүлсэн. Агентлагийн даргын 2022.06.24-ний өдрийн Б/216 дугаар тушаалаар жолоочийг ажлаас чөлөөлсөн.	Бүрэн хэрэгжсэн 100%

12	24	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	Төрийн байгууллагын цахим хуудсанд нийтэлж буй бүх мэдээ, мэдээлэл кирилл бичгээр бичигддэг. Монгол бичгээр зэрэгцүүлэн бичих ажлыг судалсан. Энэ ажлын хүрээнд нийт албан хаагчдын Монгол бичгийн чадварыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.	Хэрэгжилт хангалтгүй 30%
3Г-ын хуралдааны тэмдэглэл					

13	25	2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр 69 дугаар тэмдэглэл 2020-12-09 Дугаар 2020_69	Ү. Төрийн цахим шилжилтийн бодлогын уялдааг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэн зохион байгуулах замаар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт даалгав.	"Лайсмед" программыг хөгжүүлэх ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл болон лиценз олгох үйл ажиллагааг сайжруулахаар ажлын даалгавар боловсруулсан. Мөн программ хангамжийг хөгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - Эмийн бүртгэлийн гэрчилгээг программаас хэвлэдэг болох - Бүртгэлийн баримт бичгийг цахимаар хүлээн авах - Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспортын лиценз олгох үйл ажиллагааг цахимжуулах - Өгөгдлийн сан болон эх кодыг хүлээлгэж өгөх. - Бүртгэлийн хүсэлт илгээхэд эмийн ерөнхий мэдээлэл зөвхөн бүрэн үед л илгээгддэг болох. - 2018-2020 онд бүртгэгдээд мэдээний санд ороогүй 65 эм, 1250 БИБ-ий мэдээллийг программд нөхөж оруулсан. - 1250 эмийн АТС кодыг бүтнээр нь оруулсан. Түүнчлэн бүртгэлийн баримт бичгийг E-Mongolia цахим системээр авах туршилтын ажлыг эхлүүлсэн.	Хэрэгжих шатанд 70%
14	26	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11	XIX.1. Коронавируст халдварын дараахь нөхөн сэргээх эмчилгээг эрчимжүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг энэ оны 5 дугаар сарын 1-ээс эхлэн орон даяар зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, Соёлын сайд Ч.Номин нарт тус тус даалгав;	Эрүүл мэндийн сайдын 2022 оны Журам батлах тухай А/139 дүгээр тушаалын хүрээнд эрт илрүүлэгт оролцож буй эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийн дагуу нийт 50 эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, эмнэлэгт төлөвлөгөөт бус зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, илэрсэн зөрчлийн хүрээнд эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 265 заалт бүхий 15 улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалыг үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ЭЗХХЗГ-ын даргын А/78 дугаар тушаалаар эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд шаардлагатай лабораторийн урвалж, оношлуур, хэрэгслийн хангамжийг зохицуулах, чанар, аюулгүй байдалд хяналт тавих, зах зээлийн үнийн судалгаа хийх ажлын хэсэг байгуулагдан, төлөвлөгөө гарган ажилласан. ЭЗХХЗГ-ын чиг үүрэг болох "Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотойгоор" эрт илрүүлэгт шаардлагатай	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй

			жагсаалтыг гарган тасалдал үүсгэхгүйгээр 7 хоног болгон Эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд шаардлагатай 52 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурын нөөцийн улсын хэмжээний мэдээллийг 7 хоногт 2 удаа эрүүл мэндийн байгууллагууд, ханган нийлүүлэх байгууллагуудаас vutgei.mohs.mn програмаар авч нэгтгэн, хэрэгцээт оношлуур, хэрэгслийн жагсаалтыг ханган нийлүүлэх байгууллагуудад мэдэгдэн татан авах ажлыг зохион байгуулж ажилласан. Нөөц бүрдүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэх, мэдээлэл солилцох зорилгоор ЭМБ-уудтай 6 удаа, ханган нийлүүлэх байгууллагуудтай 7 удаа танхимаар болон цахимаар тус тус уулзалтуудыг зохион байгуулсан.	
		Х.5. 2021 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт 2022 оны эхний хагас жилийн байдлаар Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд дуудлагаар 66, цахим шуудангаар 1, дуут шуудангаар 2, веб хуудсаар 1, биечлэн 1 буюу нийт 70 гомдол, санал ирүүлсэн байна. Үүнээс 94.3% буюу 66 нь шийдвэрлэгдсэн, 5.7% буюу 4 өргөдөл, гомдол судалж буй төлөвт байна. Нийт ирсэн өргөдөл, гомдлын 55%-ийг эмийн тасалдал, эмийн хангамж, хүртээмж болон үнийн өсөлтийн асуудал эзэлж байна. Өргөдөл гомдлыг хүлээн авсан даруйд иргэнтэй холбогдон тодруулга авч, шаардлагатай тохиолдолд хяналт шалгалтыг зохион байгуулах, өөр бусад байгууллагаас мэдээлэл авах арга хэмжээг авч иргэнд эргэн мэдээлж өргөдөл, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%

27

15	28	2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16	ХҮИИ.2.4. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх хүрээнд "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяныг дэмжиж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгав.	2022 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Эрүүл мэндийн сайд, дарга нартай хамт Богд ууланд алхаж, 12-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд "Алхангаа ярилцъя" арга хэмжээнд байгууллагын 30 албан хаагч оролцож, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийлээ. ЭМС-ын санаачилсан "Дугуйн аялал 2022" арга хэмжээ 06 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан.Тус арга хэмжээнд 5 албан хаагч оролцож, эрүүл бие идэвхтэй хөдөлгөөнийг олон нийтэд уриалсан. Мөн 2022 оны 06 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Эрүүл мэндийн салбарын спортын аварга шалгаруулах "Цагаан нөмрөгтнүүд" 2022 тэмцээнд 30 албан хаагч амжилттай оролцсон.	Бүрэн хэрэгжсэн 100%
	29		ХҮИИ.17.2. Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд оруулж, ажиллахыг Төсвийн шууд захирагч нарт даалгав;	ЭЗХХЗГ-ын даргын 2022.04.26-ны өдрийн А/88 дугаар "Ажлын байрны түрээс" нэртэй тендер сонгон шалгаруулалт зохион байгуулах үнэлгээний хороо байгуулах тухай" А/89 дүгээр "Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай" тушаал батлагдсан. Үүний дагуу үнэлгээний хороо тус бүр хуралдаж, тавигдах шаардлага, тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулсан. www.tender.gov.mn -д шаардлагатай баримт бичгүүдийг оруулан 2022 оны 06 дугаар сарын 02, 06-ны өдрүүдэд тендер нээсэн. Үүний дагуу ажлын байрны түрээсийн тендерийн үнэлгээний ажил хийгдэж байна. Харин эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцогч байгууллага байхгүй байсан тул 2022.06.03-ны өдөр дахин тендер зарласан.	Бүрэн хэрэгжсэн 100%
16	30	2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2022-05-04 Дугаар 2022_27	ХҮИИ.2.13. Төрийн хүнд суртлыг арилгах авлигаас ангид байх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэхэд онцгой анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч тухай бүр нь хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	Байгууллагын 2022 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд төрийн хүнд суртлыг арилгах, авлигаас ангид байх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх талаар тусгаж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	Хэрэгжих шатанд 70%

17	31	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_	XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	“Tridum” ХХК-тай гэрээ байгуулан эхний удаад байгууллагын газар хэлтсийн дарга нар болон бичиг хэргийн ажилтанд нийт 10 хэрэглэгчид тоон гарын үсгийн төхөөрөмжийг худалдан авч хүний нөөц, бичиг хэргийн “Able” програм хангамжид холбож дотоод албан бичиг солилцох, боловсруулах үйл ажиллагааг тоон гарын үсэг ашиглан цахимаар солилцдог болсон.	Хэрэгжих шатанд 70%
3Г-ын албан даалгавар					
18	32	Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03	1.3. Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх.	“Tridum” ХХК-тай гэрээ байгуулан эхний удаад байгууллагын газар хэлтсийн дарга нар болон бичиг хэргийн ажилтанд нийт 10 хэрэглэгчид тоон гарын үсгийн төхөөрөмжийг худалдан авч хүний нөөц, бичиг хэргийн “Able” программ хангамжид холбож, дотоод албан бичиг солилцох, боловсруулах үйл ажиллагааг тоон гарын үсэг ашиглан цахимаар солилцдог болсон.	Бүрэн хэрэгжсэн 100%
19	33	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2	1.2. Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлэх;	2021 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр эмийн бүртгэлийн хэлтэсээс дараах мэдээллийг авч нэгтгэсэн. Үүнд 1. нэг удаагийн экспорт, импортын лицензийн үйл ажиллагааг цахимжуулах 2. эмийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах 3. тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах 4. эмийн гаж нөлөөний мэдээллийг цахимжуулах зэрэг үйл ажиллагааг тус тус жагсаалт гарган 2021.11.06-ны өдрийн 02/01/1279 дугаар албан бичгээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%

	34	1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх;	"Эмийн бүртгэлийн материалыг E-Mongolia цахим системээр авах бэлтгэл ажлыг хангасан. Туршилтыг эхлүүлэн цахимаар бүртгэлийн баримт бичгийг авч байна. Энэ хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1. E-Mongolia цахим системд бүртгэлийн мэдээлэл авах ажлын зураглалыг хүргүүлж, талбарыг үүсгэсэн. 2. Эмийн бүртгэлийн материалыг E-Mongolia цахим системээр авах асуудлыг ЭЗХХЗГ-ын Даргын зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. 3. "Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журам"-ын төсөлд цахим үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгасан. 4. Мөн E-Mongolia цахим системээр мэдээлэл илгээх, хүлээн авах талаарх сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Үүнд: • бүртгүүлэгч байгууллага /2022.03.15/ • бүртгэлийн мэргэжилтнүүд /2022.04.11/ • бүртгэлийн шинжээч /2022.05.10/	Хэрэгжих шатанд 70%	
	35	1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах;	Эмийн бүртгэлийн хэлтэс, Тусгай зөвшөөрлийн хэлтсээс иргэд олон нийтэд цахимаар үйлчлэх ажлуудыг олон нийтэд мэдээллэсэн. Тухайлбал Эмийн бүртгэлийн хугацаа сунгалтыг цахимаар хэрхэн хийх, Тусгай зөвшөөрлийн төлбөрийг цахимаар төлөх зэрэг мэдээллийг байгууллагын вэб сайт, фээсбүүк пэйж хуудсанд нийтэлж олон нийтэд хүргэсэн. Эм, эмийн түүхий эдийн бүртгэлийн хугацаа сунгах, Оношилгооны хугацаа сунгах алхамууд, Импортын эмийн энгийн болон түргэвчилсэн бүртгэлд бүртгүүлэх хугацаа сунгалтын цахимаар үзүүлэх үйлчилгээний мэдээллийг байгууллагын вэб сайтад байршуулсан. Цахимаар зохион байгуулагдсан хурал, сургалтын мэдээллийг байгууллагын вэб сайт болон цахим хуудсанд нийтэлж, иргэд олон нийтэд нийт 7 удаа хүргэсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%	

	36	1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем”-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох.	Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалт, хяналт, тайлагналт, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг www.internet.gov.mn домейн нэр бүхий онлайн албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн хөтөлсөн ба 2022 оны 06 дугаар сарын байдлаар нийт 7100 албан бичгийг бүртгэж шийдвэрлэн ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
Үнэлгээний дундаж дүн				90,0 хувь	